



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/16

Улаанбаатар хот

Ажлын байранд дүн шинжилгээ хийх,
албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн
боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэг, Монгол улсын Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/527 дугаар захирамж, 2022 оны А/155 дугаар захирамжаар баталсан Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн бүтэц орон тооны хязгаарыг шинэчлэн баталсантай холбогдуулан тус газрын албаны тушаал (ажлын байр)-д дүн шинжилгээ хийх, албан тушаалын тодорхойлтуудыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:	Д.Ганболд	Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга
Гишүүн:	С.Туул	Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
	О.Нямбат	Бодлогын баримт бичгийн тайлан, сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн
	Б.Энхцэцэг	Аяллын бүтээгдэхүүний хөгжүүлэлт хариуцсан мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Ш.Ундармаа	Хүний нөөц, ёс зүй дотоод ажил хариуцсан мэргэжилтэн

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, боловсруулсан албан тушаалын тодорхойлтуудыг Төрийн албаны зөвлөлд хянуулж, батлуулахыг ажлын хэсэг (Д.Ганболд)-т даалгасугай.

ДАРГА  Д.БАТСУХ

